



ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН НӨЛӨӨН ДЭХ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ИРЭЭДҮЙ: МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

THE FUTURE OF THE LEGAL PROFESSION UNDER THE IMPACT OF ARTIFICIAL INTELLIGENCE: AN ANALYSIS OF THE LEGAL ENVIRONMENT OF MONGOLIA

Ганхуягийн Гантөгс¹

Shihihutug University, E-mail: gantugs@shihihutug.edu.mn <https://orcid.org/0009-0008-4706-5908>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

хиймэл оюун ухаан,
хуульчийн мэргэжил, хуулийн
технологи, генератив,
галлюцинаци, хууль эрх зүйн
зохицуулалт

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2026, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн: 2026, 04
сар

Keywords:

Artificial Intelligence, Legal
Profession, Legal Technology,
Generative AI, Hallucination,
Legal Regulation, Mongolia

Article history:

Received March, 2026
Revised March, 2026
Accepted Apl, 2026

ХУРААНГУЙ

Дэлхий даяар өрнөж буй дөрөвдүгээр аж үйлдвэрийн хувьсгал хууль зүйн салбарын уламжлалт хэв маягийг сууриар нь өөрчлж байна. 2024 оны байдлаар олон улсын хуулийн фирмүүдийн 79 хувь нь үйл ажиллагаандаа Хиймэл оюун ухааныг нэгэнт нэвтрүүлсэн нь энэхүү технологи 'туслах' хэрэгслээс 'стратегийн түнш' болон хувирсныг илтгэнэ. Монгол Улсын хувьд 2025 онд батлахаар төлөвлөж буй хиймэл оюун ухааны үндэсний стратеги болон 'ХуульTech' зэрэг үндэсний платформуудын хэрэглээ нь технологийн бэлэн байдлыг харуулж байгаа ч, эрх зүйн орчны хувьд 'зохицуулалтын хоосон орон зай орисоор байгаа нь хуульчийн мэргэжлийн хүрээнд хиймэл оюун ухааны хэрэглээ, хариуцлага, ёс зүйн зохицуулалтыг тусгайлан зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэхүү судалгааны ажил нь хиймэл оюун ухааны нөлөөгөөр хуульчийн мэргэжлийн үнэ цэн хэрхэн хувьсаж буйг тодорхойлж, дотоодын эрх зүйн орчин дахь "галлюцинаци" болон ёс зүйн хариуцлагын асуудлыг харьцуулсан шинжилгээний аргаар судлахыг зорив.

The ongoing Fourth Industrial Revolution is fundamentally transforming the traditional paradigm of the legal sector worldwide. As of 2024, 79 percent of international law firms have already integrated Artificial Intelligence (AI) into their operations, indicating that this technology has evolved from a mere "support tool" into a "strategic partner."

In the case of Mongolia, the planned adoption of a national AI strategy in 2025, along with the use of national platforms such as "LawTech," demonstrates a certain level of technological readiness. However, from a legal standpoint, a "regulatory gap" persists, as a comprehensive legal framework governing the use of AI in the legal profession—particularly in terms of responsibility and ethical regulation—has yet to be established.

¹Шихихутуг их сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, докторант

This study aims to identify how the value of the legal profession is evolving under the influence of AI and to examine, through a comparative analytical approach, the issues of “hallucination” and ethical responsibility within the domestic legal environment.

Энэ өгүүлэл **CC BY-NC** лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

2022 оны 11 дүгээр сард буюу OpenAI-ийн бүтээсэн хиймэл оюун ухаанд суурилсан систем ChatGPT нийтэд нээлттэй болсноор хиймэл оюун ухааны хэрэглээ нийгмийн бүхий л салбарт эрчимтэй нэвтэрч эхэлсэн бөгөөд хуулийн мэргэжлийн тогтолцоо ч энэ өөрчлөлтөөс чөлөөгүй боллоо.²

2025 оны байдлаар хуулийн фирмийн 500 ба түүнээс дээш хуульчтай байгууллагуудын 47.8 хувь нь хиймэл оюун ухааны хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.³ Нэгэн дүн шинжилгээнд зориулсан судалгаанд хамрагдсан 333 хуулийн фирмийн 210 нь буюу 63 хувь нь аль нэгэн төрлийн хиймэл оюун ухааны хэрэгслийг нэвтрүүлсэн байсан нь Олон улсын хуульчдын холбоо (IBA)-ын 2024 оны тайланд тусгагдсан байна.⁴

Монгол Улсын хувьд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ) НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 онд Монгол Улсын хиймэл оюун ухааны үндэсний стратегийг баталсан.⁵ Гэвч одоогоор хуульчийн мэргэжлийн хүрээнд хиймэл оюун ухааны хэрэглээ, хариуцлага, ёс зүйн зохицуулалтыг тусгайлан зохицуулах эрх зүйн орчин Монгол Улсад бүрдээгүй байна.

Судалгааны зорилго: хиймэл оюун ухаан хуульчийн мэргэжлийн ямар чиглэлийг автоматжуулах, ямар чиглэлийг орлох боломжгүй болохыг тодорхойлохдоо Монгол Улсын одоогийн хууль эрх зүйн орчинд байгаа дутагдалтай талыг илрүүлж, мэргэжлийн хөгжлийн болон эрх зүйн зохицуулалтын бодлогын зөвлөмж гаргах явдал юм.

2. Арга зүй

Баримт бичгийн шинжилгээ - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ЦХИХХЯ-ны хиймэл оюун ухааны стратегийн баримт бичиг,

² Palmer, M. C. (2024, December 5). How lawyers can overcome fear and embrace AI in 2025. 2Civility. www.2civility.org/how-lawyers-can-overcome-fear-and-embrace-ai-in-2025/

³ American Bar Association. (2024). AI and Legal Ethics. Chicago: ABA. MIT Technology Review ABA technologyreview.com/2025/12/15/1129181

⁴ International Bar Association. (2024). The future is now: Artificial intelligence and the legal profession (September 2024). London: IBA. Эх сурвалж: ibanet.org/document?id=The-future-is-now-AI-and-the-legal-profession-report

⁵ UNDP Mongolia & Ministry of Digital Development, Innovation and Communications. (2025, February 3). Ministry of Digital Development, Innovation and Communications and UNDP partner to advance Mongolia's AI readiness and strategy. Ulaanbaatar: UNDP. undp.org/mongolia/press-releases

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтуудад агуулгын шинжилгээ хийсэн.

Харьцуулсан эрх зүйн шинжилгээ - ЕХ-ны хиймэл оюун ухааны тухай хууль (AI Act, 2024), АНУ-ын Хуульчдын холбоо (ABA)-ын 1.1-р дүрмийн хэрэгжилт, Их Британийн Solicitors Regulation Authority (SRA)-ын тогтолцоо болон БНХАУ-ын Генератив хиймэл оюун ухааны үйлчилгээний зохицуулалтын заалтуудтай харьцуулан шинжилсэн.

Тоон болон чанарын хосолсон шинжилгээ - Олон улсын хуулийн мэргэжлийн байгууллагуудын тайлан (IBA 2024, ABA 2024, Bloomberg Law 2025), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-ын ажил мэргэжлийн автоматжилтын судалгааны тоон мэдээг ашиглан дүн шинжилгээ хийсэн.

3. Судалгааны үр дүн

Хиймэл оюун ухаан гэдэг нь хүний оюун ухааны үйл ажиллагааг дуурайж сурч мэдэх, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах чадвартай компьютерын систем юм. Хуулийн салбарт хиймэл оюун ухаан нь үндсэн хоёр хэлбэрээр ялгагдах ба энэ нь тодорхой ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан хязгаарлагдмал хиймэл оюун ухаан (Narrow AI) болон тодорхойгүй өргөн хүрээний шийдвэр гаргах чадвартай ерөнхий хиймэл оюун ухаан (General AI).⁶

Хуулийн практикт ашиглагдаж буй гол хэрэгслүүдэд дараах зүйлс багтана.	Хуулийн судалгааны платформ (thomson reuters cocounsel, lexisnexis AI, harvey)
--	--

Гэрээний хянан шалгах систем

Хэргийн үр дүнг таамаглах хэрэгсэл

Баримт бичиг боловсруулах автоматжуулалт

Frey ба Osborne нар (2013) "Ажил мэргэжлийн ирээдүй" хэмээх судалгаандаа компьютержилт, автоматжилтад өртөмтгий ажлын байрны шинж чанарыг тодорхойлсон бөгөөд хуулийн салбарын нэлээд хэсэг нь эрсдэлтэй гэж үнэлжээ.⁷

Харвардын хуулийн сургуулийн профессор Дэйвид Уилкинс нь хуульчийн мэргэжлийг өөрчлөхөд хиймэл оюун ухааны нөлөөллийн хоёр туйлын байр суурийн аль нь ч бодит биш гэж үзжээ. "Бүгдийг орлоно" гэсэн болон "огт нөлөөлөхгүй" гэсэн хоёр туйл хоёулаа алдаатай бөгөөд бодит хувилбар нь ажлын мөн чанарын асуудал, тодорхой

⁶ New York State Bar Association. (2025). Will AI render lawyers obsolete? New York: NYSBA. nysba.org/will-ai-render-lawyers-obsolete/

⁷ Frey, C. B., & Osborne, M. A. (2013). The future of employment: How susceptible are jobs to computerisation? Oxford Martin School Working Paper. Oxford: University of Oxford.

ажлуудыг автоматжуулж, хуульчийн цагийг өндөр бүтээмж бүхий үйл ажиллагаанд чиглүүлэх явдал гэж тодорхойлжээ.⁸

Хиймэл оюун ухааны нөлөөлөл: автоматжих ба орлох боломжгүй чиглэлүүд

Судалгааны дүнгээс харахад хуульчийн ажлын дараах чиглэлүүд хиймэл оюун ухаанаар автоматжих өндөр магадлалтай байна:

Чиглэл	Хиймэл оюун ухааны хэрэгсэл	Автоматжилтын түвшин
Хуулийн судалгаа	Harvey, CoCounsel, LexisNexis AI (Монгол: ХуульTech)	Өндөр / хэдэн секундэд мянга мянган хэргийн шийдвэр хайна/
Гэрээний анализ	Kira Systems, Luminance	Өндөр /эрсдэлтэй заалтыг автоматаар тэмдэглэнэ/
Баримт бичгийн хяналт	Relativity, Everlaw	Өндөр /e-Discovery процессыг хурдасгана/
Нэхэмжлэлийн эхний ноорог	GPT-4, Claude, Gemini (Монгол: ХуульGPT)	Дунд /хяналт шаардана/
Хэргийн үр дүн таамаглах	Premonition, Lex Machina (Монгол: legaldata.mn хайлт)	Дунд / магадлалын шинжилгээ хийнэ/

Стэнфордын хуулийн сургуулийн профессор Жулиан Няарко (2025) "Одоогийн хэлний загварууд хүний сэтгэлгээний нэгэн чухал шинж дүр зургийг загварчлах чадвараас хоцорч байна" гэж дүгнэжээ.⁹ Энэ нь хуулийн хүнд нарийн хэрэгт хэрэгтэй нөхцөлийн сэтгэлгээнд хиймэл оюун ухаан бэрхшээлтэй байгааг харуулна.

Орлох боломжгүй чиглэл	Шалтгаан
Шүүхийн мэтгэлцээн	Нийгмийн сэтгэл зүй, нөхцөлийн сэтгэлгээ,

⁸ Wilkins, D. (2024, February 14). Harvard law expert explains how AI may transform the legal profession in 2024. *Harvard Law Today*. hls.harvard.edu/today/harvard-law-expert-explains-how-ai-may-transform-the-legal-profession-in-2024/

⁹ Nyarko, J., MIT Technology Review. (2025, December 15). AI might not be coming for lawyers' jobs anytime soon. *MIT Technology Review*. technologyreview.com/2025/12/15/1129181

Орлох боломжгүй чиглэл	Шалтгаан
	шүүгч-өмгөөлөгчийн харилцаа
Хэрэгч зөвлөх	Итгэл, нууцлал, сэтгэл хөдлөлийн дэмжлэг
Шинэ хуулийн тайлбар	Урьд тохиолдоогүй хэргийн аналогийн сэтгэлгээ
Хэлэлцээ, эвлэрүүлэн зуучлал	Харилцааны ур чадвар, хүний сэтгэл зүйн ойлголт
Ёс зүйн шийдвэр гаргалт	Хуулийн болон ёс суртахууны нийлмэл дүгнэлт

2025 оны 12 дугаар сарын байдлаар хуулийн сургуулийн 2024 оны төгсөгчдийн 93.4 хувь нь төгссөнөөс хойш 10 сарын дотор ажилтай болсон нь бүртгэлийн түүхэн хамгийн өндөр үзүүлэлт болжээ. 10 Хуулийн фирмд ажилладаг нийт хуульчдын тоо 2023 оноос 2024 оны хооронд 13 хувиар нэмэгдсэн нь хиймэл оюун ухаан хуульчийг нэн даруй орлохгүй байгааг харуулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх" зорилтыг тусгасан бөгөөд хиймэл оюун ухааныг улсын стратегийн чухал хэсэгт тооцох болсон.¹¹

ЦХИХХЯ нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Oxford Insight байгууллагын аргачлалаар Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын дэлгэрэнгүй үнэлгээг хийлгэж байна.¹² Мөн Их Британийн Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын төвтэй хамтран Монгол Улсын кибер аюулгүй байдлын судалгаа явуулж байгаа бөгөөд ЦХИХХЯ-ны сайд хиймэл оюун ухааны хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бий болгох, шинэ хуулийн төслүүд боловсруулах чиглэлд Их Британитай хамтран ажиллах хүсэлтэй буйгаа илэрхийлсэн байна.¹³

¹⁰ MIT Technology Review. (2025, December 15). AI might not be coming for lawyers' jobs anytime soon. National Association for Law Placement, technologyreview.com/2025/12/15/1129181

¹¹ Монгол Улсын Засгийн газар. (2024). Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2.1.1.3. Улаанбаатар: legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631

¹² UNDP Mongolia & ЦХИХХЯ. (2025, February 3). Ministry of Digital Development, Innovation and Communications and UNDP partner to advance Mongolia's AI readiness and strategy. undp.org/mongolia/press-releases

¹³ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2024, October 8). Хиймэл оюун ухааны хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бий болгоход Их Британи улстай хамтран ажиллана. mddic.gov.mn/eng/2024/10/19259/

Цахим засаглалын хөгжлийн индексээр 2024 онд Монгол Улс дэлхийн 193 орноос 46-д жагссан нь 28 байраар урагшилсан үзүүлэлт юм.¹⁴

Монголын LegalTech-ийн бодит кейс: ХуульTech

Онолын түвшинд хэлэлцэж байсан хиймэл оюун ухааны хуулийн хэрэглээ Монгол Улсад аль хэдийнээ хэрэгжиж эхэлсэн байна. "ХуульTech" нь Монгол хэл дээрх анхны хуулийн хиймэл оюун ухаан туслагч платформ бөгөөд Монгол Улсын бүх хууль тогтоомж болон шүүхийн шийдвэрүүдийг багтаасан мэдээллийн санд тулгуурлан хуульчдын судалгааны ажлыг хялбарчилдаг.¹⁵

ХуульTech платформд одоогоор 500 гаруй хуулийн мэргэжилтэн бүртгэлтэй байгаа нь Монголын хуулийн практикт хиймэл оюун ухаан нэвтэрч эхэлсний бодит нотолгоо юм. Тус платформ нь хуульчдын хуулийн судалгааны хугацааг эрс багасгаж, гэрээний эрсдэлийг онцолж, шүүхийн өмнөх шийдвэрүүдэд үндэслэн магадлалт үр дүн тооцдог.¹⁶

Мөн legaldata.mn платформ нь алгоритм болон хиймэл оюун ухааны хэрэглээ бүхий хуулийн мэдээллийн систем ажиллуулж байгаа нь Монголын хуулийн зах зээлд хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээний эрэлт өсөж байгааг харуулна. Гэвч эдгээр платформуудын хэрэглэгчдэд хамаарах мэргэжлийн хариуцлага, хиймэл оюун ухаан үнэн мэт худал мэдээлэл зохиох үзэгдэл нь зөвхөн техникийн алдаа биш, цаашлаад хүний нэр төр, бизнес, магадгүй үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлөхүйц эрх зүйн үр дагавартай.

Одоогийн байдлаар Монгол Улсад хиймэл оюун ухааны хуулийн практикт ашиглахтай холбоотой тусгайлсан хуулийн зохицуулалт байхгүй байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26.1.4-т заасан "үргэлжилсэн сургалт" заавал эзэмшихийг шаарддаг боловч хиймэл оюун ухаан хэрэгслийн чадамж, хязгаарлалт, ёс зүйн хэрэглээний талаар тусгай стандарт заагдаагүй байна. ХуульTech зэрэг платформуудын гаргаж байгаа мэдээлэлд тулгуурлан хуульч эцсийн шийдвэр гаргаж болох боловч энэ үүргийн хариуцлагын механизм хуульд тодорхой заагдаагүй байна.

Зохицуулалтын алдаа	Одоогийн байдал	Шаардлагатай зохицуулалт
Хиймэл оюун ухааны хэрэгслийн мэдлэгийн стандарт	Тусгайлан заагдаагүй	Хуульчийн CPD-д хиймэл оюун ухааны хэрэглээний мэдлэг оруулах

¹⁴ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2024, September). НУБ-ын Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлт. mddic.gov.mn/eng/date/2024/09/

¹⁵ <https://huuli.tech/> Монгол хэл дээрх анхны хуулийн хиймэл оюун ухаан туслагч — 500 гаруй хуулийн мэргэжилтэн ашигладаг. Улаанбаатар. huuli.tech

¹⁶ <https://huuli.tech/>

Зохицуулалтын алдаа	Одоогийн байдал	Шаардлагатай зохицуулалт
хиймэл оюун ухаанд гаргасан алдааны хариуцлага	Тодорхойгүй	Мэргэжлийн хариуцлагын тодорхой зохицуулалт
Нууцлал, өгөгдлийн аюулгүй байдал	Ерөнхий хуулиар зохицуулагдсан	Хуулийн хэрэглээнд зориулсан тусгай журам
Хиймэл оюун ухааны "галлюцинаци"-ийн хариуцлага	Хуульд заагдаагүй	Иш татсан хэргийг шалгах үүргийн тодруулалт
Хиймэл оюун ухааны тухай хууль	Боловсруулалтын шатанд	Хуулийн салбарт зориулсан тусгай хэсэг

ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШЛАГА

Хуулийн мэргэжил дэх хиймэл оюун ухааны зохицуулалтын хандлагыг олон улсын хэмжээнд авч үзвэл дараах зураглал харагдана.

152

Улс / Байгууллага	Хиймэл оюун ухааны зохицуулалтын арга хандлага	Хуульчид тавих шаардлага
ЕХ (AI Act 2024)	Эрсдэлд суурилсан ангиллын систем	Өндөр эрсдэлт хиймэл оюун ухаанд хүний хяналт заавал
АНУ (ABA)	Дүрэм 1.1 — мэдлэгийн стандарт	Хиймэл оюун ухааны ашиг тус, эрсдэлийг ойлгох чадвар шаардана
Их Британи (SRA)	хиймэл оюун ухаан хэрэглээний удирдамж гаргасан	Нууцлал, AI-ийн зохиосон мэдээллийг "үнэн" гэж шууд итгэлгүйгээр баримтаар тулгаж шалгах үүрэг тодорхойлсон

Улс / Байгууллага	Хиймэл оюун ухааны зохицуулалтын арга хандлага	Хуульчид шаардлага	тавих
БНХАУ	Генератив хиймэл оюун ухааны үйлчилгээний журам (2023)	Хиймэл оюун ухааны хэрэглээг салбар бүрт хэрэглэхдээ хариуцлагыг баталгаажуулах үүрэг	
Монгол Улс	Хиймэл оюун ухааны стратеги боловсруулалтын шатанд	Хуулийн зориулсан байхгүй	салбарт заалт

Харьцуулсан дүн шинжилгээнээс харахад АНУ-ын АВА-ын 1.1-р дүрмийн "мэдлэгийн стандарт"-ын тайлбарт хиймэл оюун ухааны мэдлэгийг мэргэжлийн чадамжийн нэг хэсэг болгосон нь Монгол Улсын хувьд суурилж болох загвар юм. Энэ загварын дагуу хуульч хиймэл оюун ухааны давуу тал болон хязгаарлалтыг ойлгож, хэрэглэх, шалгах чадвартай байхыг шаарддаг.¹⁷

Хиймэл оюун ухаан ба хуульчийг орлох бус, чадавхжуулах хувьсал

Судалгааны дүнгээс дараах дүгнэлт гарч байна. Хиймэл оюун ухаан хуульчийг бүрэн орлох боломжгүй боловч тодорхой ажлуудыг автоматжуулж, хуульчийн мэргэжлийн мөн чанарыг өөрчилнө. Цэвэр мэдлэгийн давуу тал нь ач холбогдлоо алдаж, харин тайлбар хийх, шийдвэр гаргах, ажил хэрэгч зөвлөх чиглэл улам чухал болно.

2025 оны National Bureau of Economic Research-ийн судалгааны дүнд хиймэл оюун ухаан чатботууд мэргэжлийн хөдөлмөрийн цагийн хэмжээ болон цалинд статистикийн ач холбогдол бүхий нөлөөллийг бий болгоогүй нь тогтоогдсан бөгөөд дундаж цагийн хэмнэлт ердөө 3 орчим хувь байсан нь хуульчийг нэн даруй орлох боломжгүйг нотолж байна.¹⁸

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн тоон дүн шинжилгээ

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн тоон мэдээг авч үзэхэд хуульчийн мэргэжлийн үнэ цэний өөрчлөлтийн талаар дараах дүр зураг харагдана.

¹⁷ American Bar Association. (2023). *Model Rules of Professional Conduct, Rule 1.1, Comment 8*. Chicago: ABA Publishing.

¹⁸ Gans, J. S. (2024, July). *Demand for artificial intelligence in settlement negotiations (Working Paper No. 32685)*. National Bureau of Economic Research. [nber.org/system/files/working_papers/w32685/w32685.pdf](https://www.nber.org/system/files/working_papers/w32685/w32685.pdf)

Үзүүлэлт	Тоо / Хэмжээ	Эх сурвалж
Монголын дундаж сарын цалин (2025 IV улирал)	2,877,800 төг	ҮСХ / Trading Economics, 2025
Монголын дундаж сарын цалин (2025)	2,479,600 төг (~720 USD)	ҮСХ, 2025
Шүүгчийн сарын цалин (анхан шат)	2,700,000 төг	Шүүхийн ерөнхий зөвлөл, 2023
Шүүгчийн сарын цалин (Дээд шүүх)	3,300,000 төг	Шүүхийн ерөнхий зөвлөл, 2023
2025 оны ажиллах хүчний эрэлт (улсын хэмжээ)	83,700 ажлын байр	ХНХЯ, 2025
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2025.04)	792,000 төг/сар	ХНХЯ, 2025

Эдгээр тоон мэдээнээс харахад Монгол Улсад хуульчийн мэргэжил нь дундаж цалингаас 1.5–2 дахин өндөр цалинтай мэргэжлийн ангилалд хамаарна.¹⁹ Хиймэл оюун ухаан нэвтрэлтийн нөлөөгөөр хуулийн мэдлэгийн суурийн давуу тал харьцангуй бага болох тул хуульчийн үнэ цэн нь мэргэшлийн мэргэжсэн байдал, харилцааны ур чадвар болон ёс зүйн шийдвэр гаргах чадамжид улам бүр тулгуурлах болно.

Хиймэл оюун ухаан хуульчийн мэргэжлийн үнэ цэнд хоёр зэрэгцээ нөлөө үзүүлнэ.

Нэгдүгээрт. Байнгын давтамжтай хийгддэг тодорхой төрлийн ажлуудыг автоматжуулснаас шалтгаалан хуульчийн цаг чөлөөлөгдөж, өндөр үнэ цэнтэй ажилд илүү их анхаарал хандуулах боломж нэмэгдэнэ. Энэ нь цаг тутмын орлогод биш, хэргийн чанар, хүн ам зүйн хүрэлцээнд эергээр нөлөөлнө.

Хоёрдугаарт. Хиймэл оюун ухаан ашиглах ур чадваргүй хуульчид бага үр бүтээлтэй харагдах эрсдэл үүснэ.

Дэлхийн хэмжээнд "хиймэл оюун ухаан ашигладаг хуульч — ашигладаггүй хуульчийг орлоно" гэсэн томъёолол мэргэжлийн үнэ цэний шинэ хуваагдал гарч байгааг харуулж байна. Монгол Улсын хуулийн зах зээлд 5,893 хуульч бүртгэлтэй байгаа бөгөөд

¹⁹ Шүүхийн ерөнхий зөвлөл. (2023). Шүүгчийн цалингийн мэдээлэл.

жил бүр 1,500 орчим шинэ хуульч нэмэгдэж байгааг харгалзан үзвэл ирэх 5–10 жилд хиймэл оюун ухаан мэдлэгтэй хуульч өрсөлдөх давуу тал олох нь тодорхой байна.

Мэргэшлийн үнэ цэн тогтоох хувьсагчдыг харьцуулбал:

Хуульчийн чадамжийн төрөл	Хиймэл оюун ухаанаас өмнөх үнэ цэн	Хиймэл оюун ухаан нэвтрэлтийн дараах үнэ цэн
Хуулийн мэдлэгийн суурь	Өндөр /бие даасан давуу тал/	Дунд /хиймэл оюун ухаан хурдан хайж олно/
Судалгаа, баримт бичгийн ажил	Өндөр / цаг их шаарддаг/	Бага / автоматажна/
Тайлбар, дүгнэлт гаргах	Өндөр	Маш өндөр / хүний ухаан шаардана/
Хэрэгч зөвлөх, итгэлцэл	Өндөр	Маш өндөр /хиймэл оюун ухаан орлох боломжгүй/
Хиймэл оюун ухаан хэрэгслийн мэдлэг	Тусгайлан шаардаагүй	Маш өндөр / шинэ чадамжийн суурь/

Монгол Улсын хуульчдын хувьд хиймэл оюун ухааны нэвтрэлт нь богино хугацаанд хуулийн судалгаа, баримт бичгийн боловсруулалт, анхны шинжилгээний ажлыг хурдасгаж, хуульчийн цагийг чөлөөлнө. Урт хугацааны хувьд хиймэл оюун ухаан мэдлэгийн стандарт нь мэргэжлийн тасралтгүй хөгжлийн шаардлагын нэг хэсэг болох дэлхийн хандлагыг дагах нь зайлшгүй.

Гэхдээ Монгол Улсын хуулийн практикт тусгай ач холбогдолтой асуудал бол хиймэл оюун ухааны "галлюцинаци"²⁰ буюу байхгүй хэрэг, хуулийн заалтыг зохиох эрсдэл юм. Энэ асуудал олон улсын практикт аль хэдийн тогтоогдсон бөгөөд Монгол Улсад ч хэрэгч зөвлөхүйн чадамж болон баталгаажуулах үүрэг тодорхой болох шаардлагатай.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Хуулийн зохицуулалтын зөвлөмж

²⁰ Ji et al. (2023) "Survey of Hallucination in Natural Language Generation"

- Боловсруулагдаж буй "Хиймэл оюун ухааны тухай хууль"-д хуулийн мэргэжлийн хиймэл оюун ухаан хэрэглээний тусгай бүлэг оруулах — мэдлэгийн стандарт, хариуцлагын механизмыг тодорхойлох
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тасралтгүй сургалтын заалтад хиймэл оюун ухаан хэрэгслийн мэдлэгийн чадамжийг нэмэх
- Хиймэл оюун ухааны эш татсан хэргийг шалгах, баталгаажуулах мэргэжлийн ёс зүйн үүрэг тогтоох

Мэргэжлийн хөгжлийн зөвлөмж

- Монголын Хуульчдын холбоо хиймэл оюун ухааны мэдлэг олгох тасралтгүй сургалтын хөтөлбөр боловсруулах
- Хуулийн сургуулиудад хиймэл оюун ухаан ба хуулийн практик хичээлийг заавал судлах хичээлд оруулах
- LegalTech стартапуудыг дэмжих хуулийн эрх зүйн орчин бүрдүүлэх

Судалгааны зөвлөмж

- Монгол Улсын хуульчдын хиймэл оюун ухаан хэрэглээний нөхцөл байдлыг судлах дотоодын эмпирик судалгаа явуулах
- "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-д хуулийн салбарын онцлог шаардлагыг тусгах

4. Дүгнэлт

Хиймэл оюун ухаан хуульчийн мэргэжлийг бүрэн орлох боломжгүй боловч хуулийн практикийн мөн чанарыг хувиргаж байна. Хуулийн судалгаа, гэрээний анализ, баримт бичгийн хяналт зэрэг тодорхой ажлуудын автоматжилт хурдсаж байгаа бол тайлбар хийх, хэргийг зөвлөх, шүүхийн мэтгэлцээн зэрэг хүний оролцоог шаарддаг үйл ажиллагаа цаашид ч хуульчийн гол ажил хэвээр үлдэнэ.

Монгол Улсын хувьд хиймэл оюун ухааны үндэсний стратеги боловсруулагдаж, цахим засаглалын хүрээнд томоохон дэвшил гарч байгаа нь дэвшилтэт технологийг нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн ашиглах чиглэлд эерэг суурь тавигдаж байна. Энэ нь сайн талтай хэдий ч хуульчийн мэргэжлийн хүрээнд хиймэл оюун ухааны хэрэглээ, хариуцлага, ёс зүйн зохицуулалтын тусгай эрх зүйн орчин бүрдүүлэх нь цаашдын хөгжлийн шаардлагатай алхам болоод байна.

Дэлхийн туршлагаас харахад "хиймэл оюун ухааныг ашигладаг хуульч хиймэл оюун ухааныг ашигладаггүй хуульчийг орлоно" гэсэн дүгнэлт ерөнхий дэвшил болж байгаа бөгөөд Монгол Улсын хуульчид мэргэжлийн хөгжлийнхөө нэг хэсэг болгон хиймэл оюун ухааны мэдлэг, ур чадварыг эзэмших нь зайлшгүй шаардлагатай болоод байна.

5. Эх сурвалж

Монгол хэл дээрх эх сурвалж

- Монгол Улсын Засгийн газар. (2024). Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар: legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631
- Монгол Улсын Их Хурал. (2012, 2024 оны нэмэлт өөрчлөлттэй). Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. Улаанбаатар: legalinfo.mn/mn/detail?lawId=8661
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2024). 2024 оны онцлох 10 ажил. Улаанбаатар: mddic.gov.mn/eng/2024/12/20649/
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2024, October 8). Хиймэл оюун ухааны хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бий болгоход Их Британи улстай хамтран ажиллана. mddic.gov.mn/eng/2024/10/19259/
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2025). Хиймэл оюун ухааны бэлэн байдлыг үнэлэх, үндэсний стратеги боловсруулах ажлыг эхлүүлээ. mddic.gov.mn/eng/2025/01/20689/
- Үндэсний статистикийн хороо. (2025). Монгол Улсын дундаж цалингийн мэдээ. Улаанбаатар: 1212.mn
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. (2025). 2025 онд дотоодын хөдөлмөрийн зах зээлд 83.7 мянган ажиллах хүчний эрэлт үүснэ. Улаанбаатар: mlsp.gov.mn/content/detail/3608
- ХуульTech. (2025). Хиймэл оюуны эрин үе — Монгол Улсын хуулийн салбарт хиймэл оюун ухаан хэрхэн нэвтэрч байна. Улаанбаатар: ХуульTech.huuli.tech/blogs/legal-ai-future-mongolia
- Шүүхийн ерөнхий зөвлөл. (2023). Шүүгчийн цалингийн мэдээлэл. Улаанбаатар. shuud.mn/a/451243
- Гадаад хэл дээрх эх сурвалж
- American Bar Association. (2023). *Model Rules of Professional Conduct, Rule 1.1*. Chicago: ABA Publishing.
- European Union. (2024). *Regulation (EU) 2024/1689 of the European Parliament and of the Council (AI Act)*. Official Journal of the European Union. <https://eur-lex.europa.eu>
- Frey, C. B., & Osborne, M. A. (2013). *The future of employment: How susceptible are jobs to computerisation?* Oxford Martin School Working Paper. Oxford: University of Oxford.
- Gans, J. S. (2024). *Demand for artificial intelligence in settlement negotiations* (Working Paper No. 32685). National Bureau of Economic Research. <https://doi.org/10.3386/w32685>
- International Bar Association. (2024). *The future is now: Artificial intelligence and the legal profession*. London: IBA AI Task Force. ibanet.org
- MIT Technology Review. (2025, December 15). *AI might not be coming for lawyers' jobs anytime soon*. technologyreview.com/2025/12/15/1129181
- New York State Bar Association. (2025). *Will AI render lawyers obsolete?* New York: NYSBA. nysba.org/will-ai-render-lawyers-obsolete/
- UNDP Mongolia. (2025, February 3). *Ministry of Digital Development, Innovation and Communications and UNDP partner to advance Mongolia's AI readiness and strategy*. undp.org/mongolia

-Wilkins, D. (2024, February 14). Harvard law expert explains how AI may transform the legal profession in 2024. Harvard Law Today. hls.harvard.edu

---oOo---